

# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2015 ОНЫ 2 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

## Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

### **1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 12 дугаар хуралдаан хуралдаж 2 асуудал хэлэлцэн 1 тогтоол баталлаа. Үүнд:

-Аймгийн 2015 оны төсвийг тодотгож, аймгийн төсвийн орлого зарлагыг 63283762.5 мянган төгрөгөөр баталлаа.

-Аймгийн “Байгаль хамгаалах сан”-ийн журмын төслийг хэлэлцээд дахин боловсруулж оруулахыг байгаль орчны газар болон ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болголоо.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2 дугаар сард 1 удаа хуралдаж 3 асуудал хэлэлцэн 3 тогтоол баталлаа. Үүнд:

-Монгол Улсын 2015 оны төсөвт өөрчлөлт орсонтой холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааныг зарлан хуралдуулж, аймгийн 2015 оны төсвийг хэлэлцэн тодотгохоор хуралдааны товыг тогтоолоо.

-Аймгийн 2015 оны модны хуваарьт нэмэлт оруулж, Сайхан суманд арчилгааны огтлолтоор 200 шоо метр, цэвэрлэгээний огтлолтоор 800 шоо метр шинэс модыг хэрэглээний зориулалтаар Сант сумын нутгаас бэлтгэх гэж нэмлээ.

-Эрхэлсэн салбартаа амжилт гаргасан дараах иргэдийг төрийн дээд одон медалиар шагнуулахаар уламжиллаа.

-Лхамсүрэнгийн Чойжил

Алтан гадас одонгоор

-Бооройгийн Лхагвадорж

Хөдөлмөрийн хүндэт медалиар

-Мөнхөөгийн Жаргал

Хөдөлмөрийн хүндэт медалиар

-Чойдонгийн Чимэгцэцэг

Хөдөлмөрийн хүндэт медалиар

Монгол Улсын Ерөнхийлөгч Зарлиг гарган эрхэлсэн салбартаа амжилт гаргасан Сэлэнгэ аймгийн 44 иргэнийг төрийн дээд одон медалиар шагнаж урамшуулсан байна. Үүнээс “Хөдөлмөрийн гавъяаны улаан туг”-ийн одон 1, “Алтангадас” одон 30, “Хөдөлмөрийн хүндэт” медалиар 13 иргэнийг тус тус шагнаж урамшууллаа.

### **2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:**

2014 оны аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумын Засаг даргын Тамгын газар, багийн үйл ажиллагааны үр дүнг тооцох, 2015 онд баримталж ажиллах бодлого зорилтоо тодорхойлох, аймгийн салбарын тэргүүнүүдийг шалгаруулах, аймгийн Засаг даргаас сум, агентлагийн дарга нартай гэрээ байгуулах зорилгоор “Нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөн”-ийг 2015 оны 2 дугаар сарын 6-ны өдөр зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар хамтран “Сэлэнгэд үйлдвэрлэв-2015” үзэсгэлэн худалдааг аймгийн төв Сүхбаатар хотноо зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд аймгийн нийт сум, ОХУ-ын Буриад улсын Хиагтын районы нийт 160 гаруй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэгчид өөрсдийн үйлдвэрлэсэн 90 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээр энэ удаагийн үзэсгэлэн худалдаанд оролцлоо. Сар шинийн тавгийн идээ, бүх төрлийн цагаан идээ, ноолууран хувцас, год болон хромон гутал, боловсруулж, савласан болон боловсруулаагүй хүнсний бүх төрлийн ногоо, баярын гоёл болсон өнгө загвар хийцийн өргөн сонголттой дээл хувцас, гэр ахуйн модон эдлэл, Оросын нарийн боов, булочка, бялуу, сувинер, гоймон, чихэр гээд хэн хүний хэрэгцээт, Сэлэнгэдээ үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг Сэлэнгэчүүд өргөн сонголттойгоор худалдан авлаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Германы олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн эрдэс баялагийн түүхий эдийн иж бүрэн санаачлага

хөтөлбөрийн газартай хамтран аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, Засаг даргын эрэхлэх асуудлын хүрээний агентлагийн төрийн албан хаагчдын төлөөлөл нийт 40 гаруй мэргэжилтэн албан хаагчдыг хамруулан “Стартеги төлөвлөлт” сэдэвт сургалт зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн 2015 оны ээлжит III хуралдаанаар Монгол Улсын 3 сая дахь иргэний чацуутан Мандал сумын 7 дугаар багийн иргэн Д.Гантогтох, Ш.Долгорсүрэн нарын хүү Г.Хангарьдад Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 400 дугаар тогтоолд заасны дагуу Улаанбаатар хотноо 2 өрөө байр олгох, 2015 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр мэндэлсэн 5 хүүхдэд тус бүрт нь 3 сая төгрөгийн мөнгөн шагналын хамт өргөмжлөл гардуулахаар шийдвэрлэсэн.

2015 оны 2 дугаар сарын 27-ны өдөр ОХУ-ын Буриад улсын Ерөнхийлөгч В.В.Наговицын тэргүүтэй төлөөлөгчид хил орчмын байдалтай танилцах, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор Сэлэнгэ аймгийн Алтанбулаг дахь шалган нэвтрүүлэх боомтод хүрэлцэн ирж, аймгийн удирдлагуудтай хил болон хил орчмын асуудлаар харилцан санал солилцлоо. Уулзалтаар Сэлэнгэ аймгийн Засаг дарга С.Бүрэнбат гурван асуудлаар санал тавилаа. Үүнд:

2015 оны 2 дугаар сарын 27-ны өдөр ОХУ-ын Буриад Улсын Ерөнхийлөгч В.В.Наговицын тэргүүтэй төлөөлөгчид Сэлэнгэ аймгийн Алтанбулаг дахь шалган нэвтрүүлэх боомтод хүрэлцэн ирж, аймгийн удирдлагуудтай хил болон хил орчмын асуудлаар харилцан санал солилцлоо. Уулзалтаар Сэлэнгэ аймгийн Засаг дарга С.Бүрэнбат дараах 3 асуудлаар санал тавилаа. Үүнд:

- “Нэгдүгээрт хил гааль, хилийн цэргийн ажилтнуудын зан харилцааны талаар,
- Хоёрдугаарт хилээр зорчиж буй автомашины даатгалын асуудлын талаар,
- Гуравдугаарт зорчигчдын хилээр нэвтрэх барааны мэдүүлгийг бөглөхөд хэлний хүндрэл гарч буй асуудлаар санал тавьсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт 2015 оны 2 дугаар сард нийт 21 өргөдөл, гомдол ирснээс 6 өргөдлийг шийдвэрлэж, 15 өргөдөл шийдвэрлэх шатандаа, 70361111 утсанд нийт 10 иргэн хандсанаас 5 өргөдлийг шийдвэрлэж, 5 өргөдлийг шийдвэрлэх шатандаа явж байна.

#### **Бусад ажлын талаар:**

##### **Мэргэжлийн хяналтын газар:**

Цагаан сарын баяртай холбогдуулан аймгийн хэмжээнд талх нарийн боовны 3 үйлдвэрлэл, худалдааны үйлчилгээний 79 нэгж, хүнсний 3 захад хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, халдвар хордлого гарахаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийлээ. Шалгалтын явцад илэрсэн 68 зөрчлийг арилгуулж, хууль, тогтоомж, стандарт зөрчсөн аж ахуйн нэгж, иргэнд нийтдээ 2907,0 мянган төгрөгийн шийтгэврийн арга хэмжээ тооцож бүрэн барагдууллаа.

Улсын хэмжээний үр тариа, төмс, хүнсний ногооны үрийн болон хүнсний улаанбуудайг лабораторийн шинжилгээнд хамруулах тухай Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2015 оны 01/20 дугаар нэгдсэн удирдамжийн дагуу 24 аж ахуйн нэгж, 1 иргэний 7 сортын 4580 тонн тарих үрийн улаанбуудайнаас дээж авч лабораторийн шинжилгээнд хамрууллаа. Шинжилгээнд хамрагдсан 4580 тонн тарих үрийн улаанбуудайн 2300 тонн Тарих үрийн буудайн MNS-0246:2010 стандартын чанарын шаардлага хангахгүй, 2280 тонн нь Тарих үрийн буудайн MNS-0246:2010 стандартын чанарын шаардлага хангаж байна.

Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр газар ашигласан нэг зөрчилд 1920.0 төгрөгийн шийтгэвэр, Ойн тухай хууль тогтоомж зөрчсөн нэг иргэнд 768.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцож барагдууллаа. Мөн Бороо гоулд ХХК-ийн хүсэлтээр химийн хорт болон аюултай бодисын агуулахын үйл ажиллагааг газар дээр нь үзэж дүгнэлт гаргаж хүргүүлэх, Редхилл Монголиа ХХК-ийн Улаан-овоогийн нүүрсний уурхайд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, илэрсэн

зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өгч торгуулийн арга хэмжээ тооцож ажиллалаа.

Алтанбулаг хилийн боомтоор ОХУ-руу нэвтэрч буй 124 тээврийн хэрэгсэлд тээврийн хэрэгсэлийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчлийг арилгууллаа.

**Стандартчилал хэмжил зүйн хэлтэс:**

Аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтсээс 6 сумын 16 худалдаа үйлчилгээний газруудад тохирлын үнэлгээ хийж, Шаамар, Алтанбулаг, Баянгол, Сүхбаатар сумын баталгаажуулалтын орон тооны бус салбар зөвлөлийн хурлын шийдвэрээр худалдаа үйлчилгээний газрынмөрдвөл зохих стандартын 84.0-өөс дээш хувийг хангасан 13 худалдаа, үйлчилгээний газарт, тохирлын гэрчилгээ олголоо.

Сүхбаатар, Мандал сумын 4 аж ахуйн нэгж, иргэний 5 нэрийн 15 бүтээгдэхүүнийг сайн дурын баталгаажуулалтанд хамруулж, итгэмжлэгдсэн лабораторийн сорилт, шинжилгээний дүнг үндэслэн шинжээчийн дүгнэлт гаргаж ажиллалаа.

Сүхбаатар, Алтанбулаг сумын худалдаа үйлчилгээнд ашиглаж байгаа 31 жинг баталгаажууллаа.

Айл өрх, аж, ахуйн нэгж, байгууллагын төлбөр тооцоонд ашиглагдаж байгаа 1 фазын 31 ширхэг цахилгаан тоолуурыг баталгаажуулалтанд хамрууллаа.

Шинээр ашиглалтанд орсон Баянгол сумын “Тэс петролиум” ШТС-ын 2 түгээгүүр, 4 шилэн хэмжигчийг шалгалт тохируулгад хамрууллаа.

**Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:**

**1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:**

1-р сарын 31-ний байдлаар

/мянган төгрөгөөр/

д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн төсвийн орлого	880237.9	1068713.0	121.4
2	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	655983.6	665348.6	101.4
3	Орон нутгийн төсвийн зарлага	4596512.8	3519432.5	76.6
	Үүнээс: Аймгийн төсвийн зарлага	323469.9	220071.5	68.0
	Аймгийн ОНХСангийн зарцуулалт	-	-	-
	Авто замын хөрөнгө оруулалт	-	-	-
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	594053.8	594053.8	100.0
5	Оёñû í òõãàé ø èèæ¿ëýã çî ðèòéàèòù í î ëã ñî í	3051137.6	2919409.5	95.7
6	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	485878.2	485878.2	100.0
7	Засаг даргын нөөц	44600	12985.0	29.1

2015 оны төсвийн гүйцэтгэлийн 1 ñàðû í мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 121.4 хувь, улсаасавахсанхүүгийн дэмжлэг 100.0 хувь тус тус биелэгдсэн байна. Төсвийн зарлагын гүйцэтгэл 76.6 хувийн биелэлттэй байна. Аймгаас олгох сумдын санхүүгийн дэмжлэг 100.0 хувь, Засаг даргаас олгох нөөц хөрөнгийн гүйцэтгэл 29.1 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

## 2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

№	Барааны нэр, төрөл	Хэмжих нэгж	Үнэ, ханш /төгрөгөөр/	
			2014 оны 1-р сар	2015 оны 2-р сар
<b>Нэг.Талх, гурил, будаа</b>				
1	Гурил /1-гурил/	1 кг	1200	1200
2	Талх /орон нутгийн/ том, жижиг	ш	1000, 2200	1000, 2200
3	Нарийн боов	1 кг	1800	1800
4	Элсэн чихэр	1 кг	1800	1800
5	Цагаан будаа	1 кг	2200	2200
<b>Хоёр.Мах, махан бүтээгдэхүүн</b>				
6	Хонины мах	1 кг	6500	6800
7	Үхрийн мах	1 кг	7000	7500
8	Адууны мах	1 кг	6200	6200
9	Ямааны мах	1 кг	5800	6000
10	Дотор мах цувдай	1 кг	5000	5000
11	Хиам, чанасан	1 кг	9500	9500
12	Гахайн мах	1кг	-	-
<b>Гурав.Сүүн бүтээгдэхүүн</b>				
12	Сүү /задгай/	1л	1300	1400
13	Сүү /савласан/	1л	2500	2500
14	Тараг /задгай/	1л	1500	1600
15	Хорхой ааруул	1 кг	9000	9000
16	Айраг	1л	-	3500
17	Хуурай сүү /орос/	1 кг	4000	4000
18	Өндөг	ш	320	300
<b>Дөрөв. Бүх төрлийн өөх тос</b>				
19	Ургамлын тос	1 кг	3400	3400
20	Өөхөн тос	1 кг	1500	1500
21	Шар тос	1 кг	9000	9000
22	Масло /задгай/	1 кг	3200	3200
<b>Тав.Хүнсний ногоо</b>				
23	Төмс/Монгол/	1 кг	1500	1500
24	Лууван	1 кг	1200	1500
25	Манжин	1 кг	1500	1500
26	Байцаа	1 кг	1200	1500
27	Сонгино	1 кг	2000	2000
28	Өргөст хэмх /Монгол/	1 кг	3000	3000
29	Тарвас /Монгол/	1 кг	-	-
30	Өргөст хэмх /даршилсан/	ш	3000	3000
31	Алаг салат /даршилсан/	ш	2500	2500
<b>Зургаа.Тээвэр шатахуун</b>				
32	Бензин А-80	1 л	1590	1590
33	Бензин А-92	1 л	1690	1690
34	Дизель түлш	1 л	1830	1830

## **Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:**

### **1. Архивын талаар:**

2012-2014 онд хийсэн нягтлан шалгалтын ажлын судалгаа, нөхөн бүрдүүлэлтээр хүлээж авсан баримтын судалгаа, график мөн хөмрөгийн жагсаалт зэргийг шинэчлэн Архивын ерөнхий газарт хүргүүлээ.

Нягтлан шалгалт хийх ажлын хүрээнд Худалдаа бэлтгэлийн удирдах газрын 1982-1992 оны 62 хадгаламжийн нэгжид нягтлан шалгалтын ажлыг хийлээ. Мөн аймгийн Нэгдсэн музейн хөмрөгийн 1971-2007 оны 63 хадгаламжийн нэгжид нягтлан шалгалт, эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын ажлыг хийлээ.

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Сүхбаатар сумын Мод боловсруулах комбинатын нийт 31 хадгаламжийн 6217 хуудсыг AMS программд тодорхойлон бичилт хийлээ. Үүнд: Заалт 4270, хүний нэр 30102, байгууллагын нэр 615, Газарзүйн нэр 382-ыг шивж орууллаа.

Албан байгууллага, иргэдийн хүсэлтийн дагуу давхардсан тоогоор нийт 250 гаруй иргэнд үйлчилж архивын хуулбар 119, магадлагаа 9, тодорхойлолт 21, эхийн одонгийн лавлагаа 8, цалингийн тодорхойлолт 2 гаргаж үйлчиллээ. Мөн дотоодын хэрэгцээнд 34 хадгаламжийн нэгж, 0243-р ангид Намын хорооны 1952-1953 оны баримтуудыг ашиглуулж байна.

## **Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:**

### **1. Боловсролын чиглэлээр:**

Аймгийн Боловсрол, соёлын газар, “Барсеолон” олимпын зөвлөлтэй хамтран Цагааннуур суманд цэцэрлэгийн багш ажилтнуудын дунд спортын наадам зохион байгууллаа.

Суурь боловсролын шинэчилсэн хөтөлбөрийг турших зорилгоор Сүхбаатар сумын 4-р сургуулийн Биологийн багш Д.Норжмаа, Сүхбаатар сумын 6-р сургуулийн биологийн багш Л.Гэрэлмаа, Спорт сургуулийн багш Г.Баянзаяа нартай хамтран “Хоол тэжээлийн энгийн хэлхээг загварчлах”, “Тамхины хор холбогдлыг тодорхойлох” сэдэвтэй хөтөлбөрийг хамтран бэлтгэн, Бэлчир бүсийн хими, биологийн багш нарын дунд хэлэлцүүлэг хийж, өөр өөрийн сургуулийн сурагчдад зааж туршин хөтөлбөрийг сайжруулж, түгээн дэлгэрүүлэхээр ажиллаж байна.

### **2. Эрүүл мэндийн талаар:**

Өсвөр үеийн хүүхэд залууст эрүүл мэндийн боловсрол олгож, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх зорилгоор аймгийн Эрүүл мэндийн газраас Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран 2014 оны 02 сарын 16 өдөр Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн ахлах, дунд ангийн сурагчдад “Охид хөвгүүдээ хайрлан хамгаалъя” уриан дор дэлгэцийн донтолт, өсвөр насны охид хөвгүүдийн эрүүл мэнд сэдвүүдээр сургалт зохион байгууллаа.

Аймгийн нийт эмнэлгүүдийн эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог байгуулж, эм, эмнэлгийн хэрэгслийг нэр төрөл, зориулалтаар нь 40 багцад хувааж, урилгыг хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран олон нийтэд мэдээлсэн. Тендер зарласнаас хойш хуулийн хугацаанд нийт 15 эм ханган нийлүүлэх байгууллага нэгдсэн эмнэлгүүд болон сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн тендер материалыг ирүүллээ.

### **3. Нийгмийн даатгалын талаар:**

2015 оны 02 сарын 25-ны байдлаар Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь Нийгмийн даатгалын сангуудад 3697.4 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулах төлөвлөгөөтэйгээс 3171.1 сая төгрөг хуримтлуулж төлөвлөгөөний биелэлт 85.7 хувьтай байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 17259 тэтгэвэр авагчдад 6.4 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгож, тэтгэмжийн даатгалын сангаас 12 даатгуулагчдад 42.1 сая төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдалт, жирэмсэн болон амаржсаны, оршуулгын, тэтгэмж олголоо.

Үйлдвэрлэлийн осол мэргэшлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 311 даатгуулагчид 82.3 сая төгрөгийн тэтгэвэр, үйлдвэрлэлийн ослын тэтгэмж, сувиллын зардалд олголоо.

Ажилгүйдлийн даатгалын сангаас 12 даатгуулагчдад 23.6 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олголоо.

2015 онд 5 ажил олгогч, шинээр бүртгэж 13 даатгуулагчийг албан журмын даатгуулд хамрууллаа. Засгийн газрын 2015 оны 52-р тогтоолын дагуу тэтгэвэр авагчдын тэтгэврийг нэмэгдүүлэн, Нийгмийн даатгалын сангаас болон цэргийн тэтгэврийг нэмэгдүүлэн програмд оруулах ажлыг 2015 оны 02 дугаар сарын 27-ны өдөрт багтаан дуусгаж, 2015 оны 03 дугаар сарын 01-ны өдөрт багтаанарилжааны банкинд тэтгэвэр олгох файлыг хүргүүлэхээр ажилтнуудын ажлын цагийг уртасган ажиллаж байна.

#### **4. Хөдөлмөр эрхлэлтийн талаар:**

2015 оны 1-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 823 хүн байсан бол 88 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 15 ажлын байранд 10 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 42 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 859 боллоо.

Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж буй 20-оос дээш ажиллагсадтай аж ахуйн нэгж, байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөл болон Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны судалгааг нийт сумдаас авч нэгтгэн нэгдсэн судалгаа гарган ажиллалаа.

#### **5. Нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:**

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2610 иргэнд 603.8 сая төгрөг, нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжинд 1248 иргэнд 161.4 сая төгрөг, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламжинд 1922 иргэнд 49.7 сая төгрөг олголоо.

Эхийн алдар одонтой 7857 эхэд 1000,0 сая төгрөгийн тусламж, жирэмсэн, хөхүүл нярай хүүхэдтэй 2379 эхэд 191135.8 мянгөн төгрөг, алдар цолтой ахмадуудад үзүүлэх хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд 51 иргэнд 15.9 сая төгрөгийг тус тус олголоо.

#### **6. Хүүхэд залуучууд, Биеийн тамир, спортын талаар:**

Хүүхдийн ордны дэргэдэх морин хуурын дугуйлангийн “Таван хан” хамтлаг, Баруунбүрэн сумын “Аялгуу” хамтлагийн сурагчдын “Монгол аялгуу” тайлан тоглолтыг 2015 оны 2 дугаар сарын 6-ны өдөр аймгийн төв Сүхбаатар суманд зохион байгуулж, телевизийн нэвтрүүлэг бэлтгэн нийтийн хүртээл болголоо.

Сайхан суманд аймгийн Онцгой байдлын газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс хамтран “Гамшиг онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал” сэдэвт сургалтыг зохион байгуулж, сургалтанд Ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, багийн нийгмийн ажилтнууд нийт хамрагдлаа.

Мандал сумын Түнхэл тосгоны 50 жилийн ойг тохиолдуулан Ширээний теннисний өсвөрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнд нийт 8 байгууллагын 60 гаруй өсвөрийн тамирчид 3 насны ангиллаар ганцаарчилсан болон холимог хосын төрлөөр өрсөлдлөө.

#### **Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:**

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 394 тоот тогтоолоор “Хонины ноос, Тэмээний ноос бэлтгэн Үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн, малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу Сэлэнгэ аймгийн

малчид хоршооны гишүүд, мал бүхий иргэдээс 2014 онд нийт 1909 малчид 498.8 мянган тн ноос бэлтгэж үндэсний үйлдвэрүүдэд тушаасан. Тус малчдын тушаасан ноосны хэмжээ болон үндэсний үйлдвэрүүдэд тушаасан баримтыг хуулийн хугацаанд Хүнс, хөдөө аж ахуйн яамны Мал хамгаалах санд хүргүүлж малчдад өгөх ноосны мөнгөн урамшууллыг шийдвэрлүүлээ.

Аймгийн өвс, тэжээлийн нөөцөөс урьдчилсан байдлаар өвс тэжээл, авах хүсэлтэй байгаа 8 сум 64.5 тн хивэг, 60 боодол өвс авахаар малчид, мал бүхий иргэдийн хүсэлтийг албан бичгээр ирүүлээд байна. Өвс тэжээлийг малчдад хямд үнээр олгохоор аймгийн төвийн нөөцөнд байгаа боодол өвсийг ширхэгийг нь 2000 төгрөгөөр, хивэгийг 1кг-ийг нь 350 төгрөгөөр, Орхон суманд хадгалагдаж байгаа 1200 боодол өвсийг чанарыг нь харгалзан 1200 төгрөгөөр, малд ашиглах боломжтой 600 боодол өвсийг ширхэгийг 500 төгрөгөөр, тэжээлд ашиглах боломжгүйг харалзан 300 орчим боодол өвсийг малчдад үнэгүй өгөхөөр шийдвэрлэсэний дагуу аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөөс одоогийн байдлаар 11 иргэнд 229 шуудай хивэг буюу 5.7 тн-ыг олгоод байна.

Аймгийн хэмжээгээр 2 дугаар сарын 25-ний байдлаар 3499 мал төллөж гарсан төлийн 99.6 хувь нь бойжиж байна. Он гарсаар том малын хорогдол 120 мал хорогдоод байгаа нь оны эхний малын 0.08 хувийг эзэлж байна.

1992кг адууны махны 21 дээж, үхрийн 21420 кг махны 153 дээж, хонины 5670 кг махны 189 дээж, ямааны 4220 кг махны 211 дээж, тэмээний 1260 кг махны 21 дээж, сүүний 36 дээжинд мал эмнэлэг ариун цэврийн магадлан шинжилгээ хийж баталгаажуулалт олголоо.

### **Зургаа. Газрын харилцаа, Байгаль орчны бодлогын хүрээнд:**

#### **1. Газрын харилцааны талаар:**

Аймгийн Засаг даргын захирамжаар өмнө нь гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар дундаа өмчилсөн иргэдийн хэлцлийг үндэслэн нийт 7 иргэний 9928 м<sup>2</sup> хэмжээтэй 31.3 сая төгрөгийн үнэ бүхий газрын өмчлөх эрхийг хэвээр үлдээж 17 иргэнийг хамтран өмчлөгчөөс хасч хууль тогтоомжинд заасны дагуу газар өмчлөх эрхийг нээж өглөө.

Сүхбаатар сумын иргэдээс газар өмчилж авсан нийт 10, Алтанбулаг сумын Засаг даргын захирамжаар газар өмчилж авсан нийт 15 иргэнд газар өмчлөлийн материалыг бүрдүүлэн өгч Улсын бүртгэлийн хэлтэст шилжүүлээ.

Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас Татварын хэлтсийн албан хаагчдад газар өмчлөлийн талаар мэдээлэл хийж, тус хэлтсийн албан хаагчдийн гэр бүлийн гишүүдийн нийт 85 иргэний хүсэлтийг хүлээн авч 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газраас Алтанбулаг суманд газар олгохоор төлөвлөн ажиллаж байна.

Газар өмчилж, эзэмшиж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мэргэжлийн байгууллагаар хэмжилт, боловсруулалт хийлгэсэн 39 кадастрын зургийг хүлээн авч аймгийн газрын кадастрын мэдээллийн нэгдсэн санд бүртгэж баталгаажууллаа.

#### **2. Барилга хот байгуулалтын чиглэлээр:**

“Тулга констракшн” ХХК-ийн гүйцэтгэсэн Мандал сумын нэгдсэн эмнэлгийн барилгын талаар сумын нэгдсэн эмнэлгээс ирүүлсэн хүсэлтийн дагуу “Тулга констракшн” ХХК-д зөрчил арилгуулах талаар албан шаардлага хүргүүлж, ажлыг дулааны улиралд хийхээр шийдвэрлэлээ.

Баянгол суманд баригдсан “Тэс петролиум” ХХК-ийн Шатахуун түгээх станцын барилгад улсын комисс ажиллаж байнгын ашиглалтанд хүлээлцүүлж, барилга байгууламжийн хувийн хэрэг нээлээ.

Иргэн Ц.Болдын үйлчилгээтэй 158 айлын орон сууцны барилгын 54 айлын орон сууцны барилгыг “Таван хан уул” ХХК гүйцэтгэж үйлчилгээний хэсгийн ажил

хийгдэж дуусаагүй учир орон сууцны хэсгийг улсын комисс байнгын ашиглалтанд хүлээн авлаа.

### **3. Байгаль орчны талаар:**

Ì áì ääè ñòì áì ä çèè àæèèäààä üâóóëж буй “Видовүүд”, “Өгөөж хараа”ХХК-ä î éä àð-èèääà, öüâýðèýäý öèèõ î éí ì ýðäýæèèéí ááéäóèèäää áì èí õì ä ø ààðäèèäää õàì äãñàì óòòäé ä çã ýèð ääðääí Айгаль орчин, ногоон хөгжлийн яамаí ä õçðäçèñýí .

Ñàéõàí ñòì ùí Çàñàä ääðääàñ èðççèñýí õýðýæýýí èé ì í ä áýèðäý õ óòòäé õçñýèð òàäüñàí ùг ñóäàèæаймгийн иргэдийн Оөлөөлөгчдийн Оурлúí Öýðäççèýä-äýýð õýèýèèççèýýí 2015 î í ù 19 õì ì ò õì äöì î èoor шийдвэрлэлээ.

Ерөө сумын Бугант тосгоны Сангийн гол нэртэй газар хууль бус алт олборлож байна гэсэн иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу аймгийн Байгаль орчны газар, Цагдаагийн газар, Прокурор, Мэргэжлийн хяналтын газрын хамтарсан ажлын хэсэг газар дээр нь хяналт шалгалт хийлээ. Хяналт шалгалтаар эвдрэлд оруулсан газарт экологи эдийн засгийн үнэлгээг тооцох зорилгоор солбицолын цэгийг авч, фото зургаар баримтжуулан ажиллалаа.

2014 онд ойжуулалтын ажлыг хийгээгүй буюу хангалтгүй гүйцэтгэсэн аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож хариу мэдэгдэх, 2015 онд ойгоос мод бэлтгэх хуваарь олгохгүй байх талаар сумын Засаг дарга болон иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанд чиглэл хүргүүлээ..

### **Долоо.Сум орон нутгийн талаар:**

#### **1.Баянгол сум:**

Дэлхийн зөн олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр Баянгол сумын багуудын нийгмийн ажилтан, иргэдийн Нийтийн Хурлын тэргүүлэгчид болон, багийн иргэдийн төлөөлөл, ерөнхий боловсролын сургуулийн Төгс инээмсэглэл үе тэнгийн сургагч бүлгэмийн 20 хүүхдийг “Сүрьеэ эдгэрдэг өвчин” сэдэвт сургалтанд хамрууллаа.

Тайлант сард Эрүүл мэндийн дэд сайд Д.Атармаа, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Монгол дахь салбарын ажилтан, “Пнетоккоккийн эсрэг вакцины үр дүнгийн үнэлгээ” судалгааны багийн удирдагч М.Туяа нар орон нутагт 0-5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын өвчний байдал, тусламж үйлчилгээний чанартай танилцан иргэдэд мэдээлэл хийлээ.

Сумын Эрүүл мэндийн газраас “Эх хүүхдийн эрүүл мэнд-хоол тэжээл хөтөлбөр”-ийн хүрээнд 0-5 насны 256 хүүхдийг жинлэн, 6 сар, 12 сар, 23 сартай 141 хүүхдэд олон найрлагат бичил тэжээлийн холимог, Д аминдэмийг 201 хүүхдэд уулгалаа.

#### **2.Ерөө сум:**

Тус сумын Засаг дарга Б.Сэргэлэн нь тайлант сард 2014 онд хийсэн ажлынхаа тайланг ард, иргэддээ тайлагнаж, цаг үеийн талаар мэдээлэл өгч иргэдийн сонирхсон асуултанд нь хариулт өгч тэдний санал хүсэлтийг хүлээж авлаа.

Бугант тосгоны Захирагчийн алба болон Ерөө сумын төрийн албан хаагчдын дунд хөгжилтэй хоккейн тэмцээн болон караоке дууны тэмцээнийг Бугант тосгоноос зохион байгууллаа.

Тайлант сард сар шинийн баяр болохтой холбогдуулан “Хүнсний тухай” “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай”, Архидан согтуурахтай тэмцэх тухай”, “Тамхины хяналтын тухай” хуулиуд болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах зорилгоор õääèèäää үйлчилгээ áì èí í í èèðèèí õì î èí ù çèè-èèäýý ýðèèýí üâóóèæáóé èðäýí , “Удийн цай”, цэцэрлэгийн гал тогоонд хяналт тавьж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Ерөө сумын Засаг даргын Тамгын газар, Сүхбаатар сумын иргэн Н.Ганболд нар хамтран “Сүүн Цагаан Сэтгэл” хандивын үйл ажиллагааг зохион байгуулж,



хөгжлийн бэрхшээлтэй 14 иргэн, амьжиргааны түвшин доогуур 6 иргэнд сар шинийн баярыг тохиолдуулан тавгийн идээ, гурил өгч сэтгэлийн дэм өглөө.

### 3.Жавхлант сум:

Агуйн сумын Засаг даргын Тамгын газар хамтран суманд үйл ажиллагаа явуулж буй төр төсвийн байгууллагын албан хаагчид хамрагдлаа.

Жавхлант сумын Засаг даргын Тамгын газраас “Осол гэмтлээс сэргийлье” сумын хэмжээний төр төсвийн байгууллага болон сумын ажиллагсадтай олон улсын чанартай авто тээврийн хэрэгсэл үйлдвэрлэх үйлдвэр хийлээ.

Тус сумын сумын Засаг даргын Тамгын газраас “Амны хөндийн эрүүл мэнд”, “Гар угаах арга техник”, “Шүд эрүүл бол Бие эрүүл”, “Цэвэр гар” сэдэвт сургалтуудыг ерөнхий боловсролын сургуулийн сурагчид болон, цэцэрлэгийн ахлах бүлгийн хүүхдүүд, эцэг эхчүүдэд сургалт явуулж гарын авлага тараалаа.

Сумын Эрүүл мэндийн газраас “Амны хөндийн эрүүл мэнд”, “Гар угаах арга техник”, “Шүд эрүүл бол Бие эрүүл”, “Цэвэр гар” сэдэвт сургалтуудыг ерөнхий боловсролын сургуулийн сурагчид болон, цэцэрлэгийн ахлах бүлгийн хүүхдүүд, эцэг эхчүүдэд сургалт явуулж гарын авлага тараалаа.

### 4.Зүүнбүрэн сум:

Тус сумын Засаг даргын Тамгын газраас “Үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалах нь” сэдэвт зөвлөгөөнийг зохион байгуулж, зөвлөгөөнд оролцогчдод Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалах сэргээн засварлах, Түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах хөтөлбөрүүд болон Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн талаар мэдээлэл хийн, түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийг гэрээгээр эзэмшиж байгаа 9 иргэнтэй 2015 оны гэрээ байгууллаа.

Зүүнбүрэн сумын Засаг даргын Тамгын газраас 2015 оны 2 дугаар сарын 16-нд сумын “Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, төр, төсвийн байгууллагын 70 гаруй албан хаагчдыг хамрууллаа.

Дэлхийн зөн олон улсын байгууллагын Сэлэнгэ Орон нутгийн хөгжлийн хөтөлбөрөөс ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн ахлах ангийн 125 сурагчдын дунд өсвөр үеийн эмчтэй хамтран “Сэтгэл татам охин”, “Эр зориг” сэдэвт лекцийг зохион байгууллаа.

### 5.1 аймгийн сум :

Дэлхийн зөн олон улсын байгууллага, Мандал сумын Хүүхдийн ордонтой хамтран амьжиргааны түвшин доогуур өрхүүдэд “Гэрээр айлчлах” хөтөлбөр хэрэгжүүлэх гэж байгаатай холбогдуулан сургалт зохион байгуулж, багийн цагдаа, өрхийн эмч, сургуулийн нийгмийн ажилтан, багийн засаг дарга нарыг хамрууллаа.

Тус сумын Цагдаагийн хэлтсээс зохион байгуулсан “Гэр бүлийн хүчирхийлэл” сургалтанд олон нийтийн газар архидан согтуурдаг, архины хамааралтай 10 эмэгтэйг нийгэмшүүлэх зорилгоор хамрууллаа.

Сар шинийн баярыг угтаж жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, иргэдэд нэг дороос хямд үнээр бүтээгдэхүүн худалдан авах боломжийг бүрдүүлэх зорилгоор “Мандалд үйлдвэрлэв” цагаан сарын үзэсгэлэн худалдааг орон нутагтаа зохион байгуулж Хэрх, Түнхэл тосгон болон төвийн багуудыг хамрууллаа. Үзэсгэлэн худалдаанд нийт 20 хоршоо, нөхөрлөл, хувиараа хөдөлмөр эрхлэгчид 37 төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 5343.0 мянган төгрөгийн борлуулалт хийлээ.

### 6.Орхонтуул сум:

Тус сумын иргэн Д.Ганхуяг Улсын тэргүүний тариаланч, газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “Агрошим”ХХК нь Улсын тэргүүний тариаланч хамт олон, Улсын аварга малчнаар Г.Даваадорж нар шалгарлаа.

2015 оны эхэнд сумын дүнгээр тэмээ377, адуу12928, хонь102616, ямаа74249 бүгд 207798 толгой мал тоологдсоноос нийт малын 45,2 хувийг буюу

93992 хээлтэгч мал эзэлж байна. Оны эхний 2 сарын байдлаар 108 толгой мал зүй бусаар хорогдсноос адуу8, үхэр11, хонь35, ямаа54 толгой хорогдлоо. Оны эхний төллөх 93992 хээлтэгчийн 14.7 хувь нь буюу 13852 толгой хээлтэгч мал төллөж гарсан төлийн 99.7 хувь нь бойжиж байна.

Сумын төсвийн орлогод 1825.0 мянган төгрөг орж 73.8 хувийн биелэлттэй байна.

#### **7.Сант сум:**

Жижиг дунд үйлдвэрлэл, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, өрхийн аж ахуй эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг худалдан борлуулах, ард иргэдэд сурталчилан таниулах зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Цагаан сар 2015” үзэсгэлэн худалдааг 2015 оны 2 дугаар сарын 6-ны өдөр зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд 22 иргэн 8 аж ахуйн нэгж байгууллага өөрсдийн үйлдвэрлэсэн сүү цагаан идээ, хүнсний ногоо, даршилж нөөшилсөн бүтээгдэхүүн, гурилан бүтээгдэхүүн, годон болон буриад монгол гутал, оёмол бүтээгдэхүүн, монгол үндэсний хувцас, модон эдлэл, гэр ахуйн тавилга зэрэг нийт 82 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 3825.0 мянган төгрөгийн борлуулалт хийлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор сумын Эрүүл мэндийн төвөөс “Эрүүл мэндийн өдөрлөг” арга хэмжээг зохион байгуулж, нийт 80 гаруй иргэн хамрагдаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нэг зорилгын дор нэг багт нэгтгэж чадлаа.

Ахмад настнуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор Насан туршийн боловсролын төв, Соёлын төв хамтран “Дуулах өдөр” дуун цэнгүүнийг зохиож явуулж, 50 гаруй ахмад настан оролцлоо.

#### **8.Сүхбаатар сум:**

Жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг “Цасны баяр” арга хэмжээ Сүхбаатар суманд 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр Сайхны хөтөл цанын баазад Биеийн тамир спортын газар тус сумын Засаг даргын Тамгын газар Барселон олимпын зөвлөл хамтран зохион байгууллаа.

Монгол Улсын 3 сая дахь иргэний үе чацуутан Сүхбаатар сумын Хонгор морьтын 1-р багийн иргэн П.Мягмаржавын 3 дахь хүү болон 2015 оны 01 дүгээр сарын 24-ний 18 цаг 36 минутанд мэндэлжээ. П.Мягмаржав хүүдээ 3 сая дахь иргэнтэй үе чацуутан болон мэндэлснийг нь билэгшээн Мянган баяр гэсэн нэр хайрласан байна. М.Мянганбаяр хүү Монгол Улсын иргэний бүртгэлд 3.000.136 дахь иргэнээр бүртгэгдсэн байна. Сумаасаа тодорсон 3 сая дахь иргэндээ Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга, Хонгорморьтын 1-р багийн Засаг дарга нар хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг гардууллаа.

Сүхбаатар суманд нийт 2127 ахмад настан амьдран суудаг ба тэднээс 895 ахмад настан харъяалалгүй гэсэн ангилалд багтаж байна. Эдгээр ахмадуудад Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу хүндэтгэл үзүүлэх ажлыг Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газраас 2015 оны 2 дугаар сарын 12-оос 16-ны хооронд амжилттай зохион байгууллаа.

#### **9.Алтанбулаг сум:**

2015 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр Монгол Улсын гурван сая дахь иргэний чацуутан Алтанбулаг сумын иргэн Жаргалсайхны гэр бүлд түүхэн цагт түүчээлэн ачит аав, энэрэлт ээж, өргөн олныхоо магнайг тэнийлгэж мэндэлсэн баярт үйл явдал болж, хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгууллаа.

Тус сумын Засаг даргаас, Сүхбаатар сумын Засаг даргатай түлээний мод бэлтгэх зориулалтаар гэрээ байгуулж, Алтанбулаг сумын 120 гаруй иргэдэд ахуйн зориулалтаар 558 м<sup>3</sup> түлээний модыг олгоод байна.



### **13.Шаамар сум:**

Тус сумын Засаг даргын Тамгын газраас 17-р жарны Хөх модон хонин жилийн Хаврын тэргүүн сарын уламжлалт сар шинийн баярыг тохиолдуулан сумын ахмад настнууд, азай буурлуудад хүндэтгэл үзүүлэх “Буянтай буурлууд-2015” арга хэмжээг 2015 оны 2 дугаар сарын 14-ний өдөр зохион байгууллаа.

Сумын иргэдийн санал санаачлагаар “Сумандаа үйлдвэрлэв” орон нутагт үйлдвэрлэгдэж буй бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг сар шинийн баярыг тохиолдуулан зохион байгуулж, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнүүд болох сүү цагаан идээ, мах махан бүтээгдэхүүн, төмс хүнсний ногоо, дахин боловсруулсан бүтээгдэхүүн, жимс жимсгэнэ, зөгийн балны бүтээгдэхүүн болон арьс нэхий ноосон эдлэлийн зэрэг олон нэр төрлийн үзэсгэлэн худалдааг 2 өдрийн турш зохион байгууллаа.

### **14.Түшиг сум:**

Тайлант сард тус сумын Засаг даргын Тамгын газраас “Иргэдийн санал хүсэлтийг хүлээж авах 4411” арга хэмжээг зохион байгуулж, сумын төр төсвийн байгууллагууд 2014 оны үйл ажиллагааныхаа талаар иргэдэд мэдээлэл хийж, иргэдийн санал хүсэлтийг хүлээж авч, нийт 80 гаруй иргэн хамрагдлаа.

2015 оны 2 дугаар сарын 1-ний өдөр Эрүүл мэндийн дэд сайд Атармаа нь сумын иргэдтэй уулзалт зохион байгуулж, Шийдлийн Засгийн газраас эрүүл мэндийн салбарын талаар баримтлан ажиллаж буй бодлого зорилтын талаар мэдээлэл хийж, иргэд хөдөлмөрчдийн санал хүсэлтийг хүлээн авлаа.

Тус сумын сум хөгжүүлэх сангийн тэргүүлэх чиглэл батлагдсаны дагуу төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөл хуралдаж нийт 15 төсөлд 196.2 сая төгрөгийн санхүүжилт хүссэн төслийг хэлэлцэн 6 төсөлд 52.2 сая төгрөгийг олгохоор шийдвэрлэлээ.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР